



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

「 Налайх дүүргийн “Чандмань Налайх”
ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй барилгыг
акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 202 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/38 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй нийт 227,094,849 (хоёр зуун хорин долоон сая ерэн дөрвөн мянга найман зуун дөчин ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилгыг актлан, данс бүртгэлээсээ хасаж өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглаж болох материалыг худалдан борлуулж 2,034,000 (хоёр сая гучин дөрвөн мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА

М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 02 дугаар сарын 07
-ний өдрийн А/23 тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

/төгрөгөөр/

Д/Д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Байршил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Тайлбар
1	Конторын барилга	1965	НД-ийн 2 дугаар хороо	227,094,849.00	7,325,640.24	219,769,208.76	Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 лгы 02-07-119/636 дугаар акт
Нийт				227,094,849.00	7,325,640.24	219,769,208.76	